

## МОНГОЛД ТОТАЛИТАР ДЭГЛЭМ ТОГТОХОД ИНСТИТУЦИЙН

### (ДҮРМИЙН) ГҮЙЦЭТГЭСЭН ҮҮРЭГ

**Ч.Тамир** багш, докторант

МУИС, НШУС, Социологийн тэнхим

(“ХХ зууны Монголчуудын улс төрийн оролцоо” сэдэвт судалгааны ажлын хүрээнд энэхүү өгүүлэл хэвлэгдэж байгаа болно.)

#### 1. Ном зохиол судлал ба судалгааны аргазүй

Түүхийн цаг хугацаа өнгөрөх тусам социализмын үеийн монголын нийгэм, улс төрийн системийг судалж шинжилсэн бүтээлүүдэд шинжилгээ хийж тодорхой цаг үеийн хувьд өөр хоорондоо ихээхэн зөрчилтэй дүгнэлтүүд зэрэгцэн оршиж байгаа асуудлыг илүү нарийвчлалтай учир шалтгааныг ялган зааглаж судалж, тохирсон үнэлэлт, дүгнэлт өгөх шаардлагатай байна. Социалист тогтолцооны монгол хувилбарыг судлах судлаачдын 3 янзын үндсэн дүгнэлт зонхилж байгаа гэдгийг хэлэх хэрэгтэй.

**1. Эхний чиглэл:** Тухайн үед оршин буй системийг тоталитар дэглэм гэж үзээд дэлхийн бусад ижил дэглэмтэй улс орнуудтай ижил төсөөтэй олон шинж чанарыг дурдсан байдаг. Академич Ж.Болдбаатар, Ч.Дашдаваа нар өгүүлэн буй үеийн авторитари дэглэмээс 1960-иад оны дунд үе гэхэд тоталитар дэглэм рүү шилжсэн гэж үзээд нийгэм эдийн засаг, улс төр, соёл нийгмийн үндсийг нь гүнзгий тайлбарлажээ. Тэд “Монголд нэг хүний ганцаар захирах авторитари дэглэм улс төрийн их хэлмэгдүүлэлтийн үед бүрэлдсэн бөгөөд төр намын тогтолцооны хэлбэрээр төлөвшиж тогтож байв. Х.Чойбалсан насан өөд болсны дараа 1952 онд БНМАУ-ын Ерөнхий сайдын албыг Ю.Цэдэнбал хаших болж, улс төрийн авторитари дэглэмийн өвийг нам төрийн тогтолцооны хэлбэрээр үргэлжлүүлэхийг санаархжээ. 1960-аад оны дунд үе гэхэд Ю.Цэдэнбалын бий болгосон номенклатурчдын шинэ анги бүрэлдэж, Монгол орон улс төрийн тоталитари дэглэмийн ноёрхолд автжээ” гэжээ. (Ж.Болдбаатар, Ч.Дашдаваа, 2005)

Мөн улс төр судлаач Д.Ганбат дурьдан буй үеийн тоталитар тогтолцоотой байсан гэж үзээд “зөвхөн нэг ангийн засаглалын утгыг өөртөө агуулан өөрчлөгдөж, эцсийн бүлэгтээ нэг намын ноёрхлыг тогтоох хөрс нь болсон юм. Энэ нь ангийн шинж чанарыг гол болгосон улс төрийн дэглэмийн тоталитар хэв маягийг бий болгоход хүргэсэн билээ. Эрдэмтдийн гаргасан тоталитаризмыг танин мэдэх арга зүйн үүднээс монгол улсад 1921 оноос хойш, ялангуяа 1930-аад оны их хэлмэгдүүлэлтийн үеэс эхлэн тоталитар бодлого бүхий нам, төрийн

хосолсон улс төрийн дэглэм тогтсон гэж үздэг нь бүрэн үндэстэй юм” гэсэн байна. (Д.Ганбат, 2007)

Манай нэрт социологич Х.Гүндсамбуу “хорьдугаар зууны монголд социализм байсан эсэх нь маргаантай ч, захиргаадлын хүнд сурталт-тоталитари тогтолцоо байсан нь ямар ч маргаангүй. Миний төсөөллөөр монголд тоталитари тогтолцоо бүрэлдэх хоёр шимт хөрс байсны нэгдэх нь дорны деспотизм, хүй элгэний хийгээд нутаг усныхны социализм” хэмээн тоталитаризм үүсэх болсон шалтгааны талаар санал дэвшүүлжээ. Тэрээр цааш нь “ХХ зууны монголд эхлээд нэг хүний буюу Х.Чойбалсангийн дараа нь бичил бүлгийн буюу Ю.Цэдэнбал тэргүүтэй МАХН-ын Төв хорооны Улс төрийн товчооны гишүүдийн дарангуйлал тогтож, тэр нь 1990 оны ардчилсан хувьсгалын эхэнд унасан билээ (Гүндсамбуу.Х, 2004) хэмээн Чойбалсангийн ба Цэдэнбалын дэглэмийг нэг ба бичил бүлгийн гэж ялгасан гаргасан боловч энэ үеийг ерөнхийд нь захиргаадлын хүнд сурталт-тоталитар тогтолцоо хэмээн ерөнхийд нь тодорхойлсон.

Философич Г.Чулуунбаатар энэ тухай өөрийн байр суурийг илэрхийлжээ. “Тэрчлэн уламжлалаасаа тасарч тоталитари дэглэмийн хэв ёсонд олон жилээр дассан манай ард түмний хувьд ардчилсан орчин үеийн хэлбэрүүдийг шууд хүлээж авах суурь бэлтгэл дутсан тал ч бий” (Г.Чулуунбаатар, 1994) хэмээн дээрх байр суурийг илэрхийлсэн байна. Философич Б.Батчулуун өөрийн бүтээлдээ өгүүлэн байгаа цаг хугацааг коммунист төр хэмээн тодорхойлоод тоталитар төр гэсэн ангилалд багтаажээ. Тэрээр “Коммунист төртэй адил үйл ажиллагаа аллага хавчлага явуулж байдаг төр бол фашистуудын төр юм. Иймэрхий маягийн төрүүдийг ерөнхийд нь тоталитари төр хэмээн тодорхойлж болно” гэжээ. (Б.Батчулуун, 2003)

Харин хуульч Б.Чимид энэ тухай бичихдээ улс төрийн тоталитар дэглэм гэдгийг онцлоод “өөрчлөлт шинэчлэлтийн тэр хөдөлгөөн улс төрийн тоталитар дэглэм бүхий нийгмийн хуучин байгууллын өөрөөр хэлбэл “социализм”-ын хүрээнээс хальж гарахааргүй реформын шинжтэй байсан гэж хэлж болох билээ” гэжээ. (Б.Чимид, 1995)

Харин судлаач А.Цанжид уг асуудлыг шалгууртай холбон тайлбарласан юм. “Тоталитар дэглэм байсан уу үгүй юу гэдгийг шийдвэрлэхэд шалгуурын асуудал чухал юм. Бидний саналаар 2 төрлийн, эсхүл 2 бүлэг шалгуур байж болох юм. Нэгд төрийн хяналтын хүрээг авч үзэх нь оновчтой мэт санагдана. Хоёрт төрийн шинж чанарыг (үүнийг манайд улс төрийн дэглэм ч гэж нэрлэдэг) болох талтай. Дээрх шалгууруудыг манай улсын өмнөх Үндсэн хуулиуд, ялангуяа 1960 оны үндсэн хуулиар тодорхойлогдсон төрийн шинж чанарт хэрэглэх юм бол төр тоталитар байсан гэдгийг хүлээн зөвшөөрөх учиртай нь илт юм. Харин эл дүгнэлттэй сал нийлдэггүй хүмүүс социалист орнуудад оршин тогтнож байсан улс төрийн дэглэмийг Гитлерийн болон түүний төсөөтэй бусад дэглэмүүдтэй харьцуулсны үндсэн дээр хуучин социалист орнуудад, түүний дотор Монгол улсад тоталитар дэглэм байгаагүй гэж үзэх нь бий”. (А.Цанжид,

1999) Энд монголыг тоталитар дэглэмтэй гэж үзвэл ямар шалгуураар авч үзэх ингэвэл тоталитар гэж дүгнэж болно хэмээгээд гэхдээ сонгодог тоталитаризмтай харьцуулбал уг дүгнэлтийг зөвшөөрөхгүй байх үндэслэл бий гэдгийг дурджээ.

Улс төр судлаач А.Юндэндорж монголын нийгмийг хуучин СССР ба Дорнод Европын орнуудтай ижилхэн тоталитар дэглэмтэй байсан гэж үзсэн бол улс төр судлаач Б.Болд-Эрдэнэ “нийгмийн тоталитар тогтолцоог ардчилсан нийгмийн тогтолцоогоор сольж өөрчилсөн” (Б.Болд-Эрдэнэ, 2000) хэмээн дүгнэсэн нь бий. Улс төр судлаач Ч.Өлзийсайхан энэ асуудлыг хөндөхдөө улс төрийн элитийн судалгаатай холбогдуулан тоталитар дэглэмтэй байсан санааг дэмжсэн. (Ч.Өлзийсайхан., 2003)

Мөн эрдэмтэдийн бүтээлээс гадна зарим нэг судалгаа сургалтын хамтын бүтээл дээр дээрх байр суурийг нийтлэг илэрхийлсэн байна. Тухайлбал: “УТБА-ийн лекцийн эмхэтгэл” гэсэн бүтээлд “Коммунист улсууд болон БНМАУ тоталитаризмын зүүн хэлбэрийн шинэчлэгдсэн хувилбар болсон хэдий ч мөн чанартаа дээр дурдсан шинж бүрэн илэрсэн тул уг дэглэмийн ангилалд багтан судлагдах бүрэн үндэстэй билээ” гэж тодорхойлжээ. (УТБА-ийн лекцийн эмхэтгэл, 2001) Манай улс төр судлалын анхны сурах бичигт гэсэн тоталитар гэсэн ангилалд оруулж “Сталины коммунизм, хуучин социалист системийн орнууд, түүний дотор Монголын социализм, Муссолиний фашизм, Гитлерийн нацизмыг тоталитар дэглэмийн сонгодог жишээ болгон авч үздэг. Энэ нь тэдгээрийн үүсэн бий болсон түүхэн нөхцөл, зохион байгуулалт, үзэл номлол зорилгодоо хүрэх арга зам зэрэгтэй холбоотой” хэмээн тайлбарласан. (Улс төр судлал, 2002)

**2. Хоёрдугаар чиглэл:** Өгүүлэн буй үеийг авторитар дэглэмтэй байсан гэж дүгнэдэг, үзэл бодолтой эрдэмтэд, судалгаа шинжилгээний материал цөөнгүй бий.

Улс төр судлаач Ю.Атар авторитар дэглэм ноёрхсоныг намын төвлөрсөн удирдлагын дарангуйлал, үндсэн хууль, эдийн засгийн үндэс зэрэгтэй холбон судалжээ. Тэрээр “Авторитар дэглэм 1960 он гэхэд Монгол оронд “социалист үйлдвэрлэлийн харилцааг ялуулж” нийгэм, төр, хувь хүн, тодорхой байгууллага бүрийн хувь заяа, ажил үйлсийг зөвхөн төрийн өмчийн хэмжээ, хүчин чадлаас шууд шалтгаалдаг горимд оруулж, улмаар төрийн өмчид улс орны бүх ачааг үүрүүлээ” хэмээн ямар ч эргэлзээгүй авторитар дэглэм хэмээн үзжээ. (Ю.Атар, 1997)

Улс төр судлаач Ц.Ганболд монголыг судлахдаа дэлхий нийтийн түүхийн тухайн цаг үеийн урсгал дээр нь буулган үзэхийг эрмэлзээд авторитар гэдэг томъёололд нь оруулсан. “Аливаа авторитар дэглэмээс ардчилсан дэглэмд шилжиж буй улс оронд заавал хэрэгжүүлбэл зохих бүх нийтийн чөлөөт ардчилсан сонгууль явуулж, парламентет ёсны үндэс суурийг тавьж, түүхэндээ анх удаа Монгол улсын Ерөнхийлөгчийг бүх нийтээрээ шууд сонгодог болж,

...зорилтыг хэрэгжүүлж байна. (Ганболд, Ц., 1997) хэмээн Монгол авторитар дэглэмтэй байсан гэсэн санааг дэмжсэн. Мөн улс төр судлаач Ё.Довчин өөрийн бүтээлдээ авторитар гэсэн нэр томъёог түгээмэл ашиглаж тал нутгийн улс төрийн соёлыг дэлгэрэнгүй тайлбарласан. (Ё.Довчин, 2000)

Харин түүхч Б.Ралгаа авторитаризм гэдгийг нэр томъёоны хувьд тайлбарлаад монголын нийгэм авторитар дэглэмтэй байсан гэж үзэж нийгмийн сэтгэлгээ, онолын салбарт, улс төрийн салбарт, эдийн засгийн салбарт гэсэн гурван хэсэг хуваан судалжээ. Тэрээр “Энэхүү авторитари дэглэмийн үед тухайн улс орны төрийн дээд эрх мэдэл нь улс төрийн ганц бүлэглэлийн, ихэвчлэн нэг намын гарт бүрэн орж, нийгмийн амьдралын бүхий л талыг зөвхөн өөрсдийн эрх ашигт зохицуулан удирдах, засаглах эрх мэдлээ тэд дарангуйлал, улс төрийн харгислал, цөллөг, олон түмнийг үзэл санааны төөрөгдөлд оруулах, нийгмийн амьдралын бүхий л талыг үзэл сурталжуулах зэрэг ихээхэн хор хөнөөл бүхий аргуудад түшиглэн хэрэгжүүлж байдаг. Авторитар дэглэмийг Монгол оронд тогтоож, түүнийг олон арван жил бэхжүүлж ирсэн МАХН, түүний удирдлага чухамхүү колони орон дахь авторитаризмын шинжийг өөртөө агуулж байлаа” гэж дүгнэсэн юм. (Б.Ралгаа, 1998) Түүхч С.Чулуунбаатар авторитар төрийн онцлогийг тодорхойлсон. “1990 оны эх гэхэд Монгол орны нийгмийн амьдралын “унтаа” байдал өөрчлөгдөж, улс төрийн авторитарт дэглэмийн бүхий л “эрэг шураг” сулран ганхаж эхлэв.” (С.Чулуунбаатар, 1995)

**3. Гуравдугаар чиглэл:** Дээрхээс гадна авторитар ба тоталитар гэсэн нэр томъёог өөр хооронд нь төдийлөн ялгалгүйгээр зэрэгцүүлэн хэрэглэсэн нь бас тохиолдоно. Түүхч М.Санждорж, улс төр судлаач Д.Чулуунжав нарыг дурдаж болно. Тухайлбал М.Санждорж өөрийн судалгааны хэсгийг Улс төрийн авторитар дэглэм гэж гарчигласан мөртлөө дотор нь тоталитар гэсэн ойлголтоор Цэдэнбал ба Чойбалсангийн дэглэмийг ялган үзэх саналыг дэвшүүлжээ. Түүний энэ санаа нь өмнө дурдсан социологич Х.Гүндсамбуугийнхтай адилаар бөгөөд “Ю.Цэдэнбалын дэглэм, Х.Чойбалсангийн дэглэм хоёрыг нэгэн төвшинд тавьж, ижил тоталитар гэж нэрлэж боломгүй байна. Чойбалсангийн үед ганц түүний захиргаадалт байсан бол Цэдэнбалын үед түүгээр толгойлуулсан цөөн хүнтэй бүлгийн захиргаадалт байв (М.Санждорж, 1995) гэжээ.

Улс төр судлаач Д.Чулуунжав авторитар ба тоталитар гэсэн нэр томъёог хоёуланг нь зэрэгцүүлэн хэрэглэсэн. “Монгол нь ингэж тусгаар тогтносон нэртэй ч хараат, колони шахуу орон, эрх чөлөөтэй нэртэй ч хуарангийн социализмын хатуу дэглэм ноёрхсон орон, социалист нэртэй ч Москвагийн төлөөний нэгдүгээр хүний хэмжээгүй эрх, авторитаризм ноёрхсон орон, хоцрогдсон Оросын эзэнт гүрний хөгжлөөр нэн дорой хязгаар нутаг, түүний түүхийн эдийн хавсрага орон болжээ. 1989, 1990 он гэхэд Монгол оронд: -Бүгдийг цагдан захиргаадах тоталитари систем, нэг намын дарангуйлал тогтсон,-Нам төвтэй төрийн амьдралд бүхэлдээ авторитари дэглэм ноёрхсон, (Д.Чулуунжав, 2006) хэмээн тодорхойлжээ.

Тойм төдий судалгаанаас харахад ямартай ч монголд ноёрхож байсан дэглэм нь ямар ч тохиолдолд авторитар ба тоталитар гэсэн дарангуйллын дэглэмийн хүрээнд өрнөх ёстой гэдгийг харуулж байна. Гэхдээ сүүлийн үед уг хоёр дэглэмийг маш олон зүйлээр ялгаж нарийвчлан судлах болсон. Энэ тухай нэрт улс төр судлаач Алмонд нар бичихдээ “наад зах нь бүх тоталитар системүүд нь авторитар байдаг бол авторитар системийн ихэнхи нь тоталитар биш байдаг” (Г.Алмонд нар, 2000) гэсэн нь уг асуудлыг нарийвчлан сайтар судлах ёстой гэдгийг харуулж байна. Улс төрийн дэглэмийг ардчилсан, авторитар, тоталитар гэж тусад нь гурван үндсэн хэсэгт хуваан үзэх судалгаа ч хийхгдэх болсон. Тухайлбал АНУ-ын Иелийн их сургуулийн профессор улс төрийн социологич Жиан Линз өөрийн судалгааны бүтээлдээ ийнхүү ангилжээ (Linz, 2000).

Тиймээс монголд дарангуйлагч дэглэмийн ноёрхож байсан цаг хугацаа, шинж чанар, үндэслэл, шалгуур зэргийг нарийвчлан судлах шаардлагатай. Өдгөө түүхийн зурвас хэсгийг сэтгэл хөдлөлөөр дүгнэх, эс бөгөөс бүхэлд нь хамааруулан нэгэн утгатай том дүгнэлт өгөх явдал нь шинжлэх ухааны танин мэдэхүйн хэрэгцээ, шаардлагыг хангаж чадахаа болиод байна. Тиймээс тухайн дэглэмийн ноёрхогч элит бүлэг, лидерүүдийн эрх мэдлийн төлөөх тэмцэл, өгсөлт ба уруудалт, зөрчил зэргийг харьцуулан судлах нь тухайн цаг үеийн дэглэмийн үнэн нүүр царайг харуулахад ихээхэн чухал байх болов уу.

Тоталитар дэглэмийн гол шалгуурыг Карл Фридрихын тодорхойлсноор “нэгдүгээрт тоталитар үзэл суртал, хоёрдугаарт энэхүү үзэл суртлыг номлогч нэг манлайлагч, нэг дарангуйлагчаар удирдуулсан нэгдмэл нам, гуравдугаарт дэглэмийн дайсныг олж цээрлүүлэхийн тулд оршдог нууц цагдаагийн газар, дөрөвдүгээрт эдийн засаг, ОНМХ, зэвсэгт хүчинд тавих монополь хяналт тус тус болно” (Э.Гидденс, 2000). Хэрвээ Фридрихын дэвшүүлсэн шалгуурыг үндэслэл болговол өгүүлэн буй хугацаанд хоёрдахаас бусад шалгуур нь монголын нийгмийг тоталитар дэглэмтэй байсан гэдгийг харуулахад маргаан гарахгүй юм. Харин хоёрдугаар шалгуур дээр төвлөрөн тоталитар уу эсвэл авторитар уу гэсэн маргаан өрнөдөг. Тиймээс уг судалгаа нь “нэг манлайлагч, нэг дарангуйлагчаар удирдуулсан нэгдмэл нэг нам” гэсэн хоёрдугаар шалгуур дээр төвлөрөн өгүүлэн буй үеийн МАХН-ын удирдлага, дүрэм, журам, бүтэц зохион байгуулалт, шийдвэр гаргах механизм, лидерүүд, хамтын удирдлага зэргийг нарийвчлан судлах юм. Ингэснээр өмнө өгүүлсэн улс төрийн дэглэмийн хэв маягийн талаархи түүхч, улс төр судлаач, социологичдын өнөөдрийг хүртэл дэвшүүлээд байгаа үндсэн таамаглалыг батлах, эсвэл няцаах бололцоог бидэнд олгох юм.

Энэхүү судалгааны ажлын гол зорилго нь өгүүлсэн хоёрдугаар шалгуур монголд үйлчилж байсан эсэхийг шалгахад оршино. Уг ажил социализмын үеийн монгол нь 1940-1990 он хүртэл тоталитари дэглэмтэй байсан, энэ дэглэм нь ялгаатай хэв маягууд байсан гэсэн таамаглал юм. Үүнд Чойбалсангийн ба Цэдэнбалын дэглэмийг өөр хооронд нь харьцуулан авч үзэж дүгнэх болно.

Үүний тулд зарим нэг ойлголтыг тайлбарлая.

**Нэгдүгээрт:** Бид судалгааны энэхүү хэсэг нь 1940-1990 оноор зааглан үзсэн. Ингэж түүхийн зурвас үеийг хэрчин авах болсон шалтгаан нь **нэгдүгээрт** 1940 он гэхэд хэлмэгдүүлэлт ерөнхийдөө шувтарч монгол улс зөвлөлтийн дагуул улс болох хувь заяа эргэлт буцалтгүйгээр шийдэгдсэн, үндэсний ардчилсан хувьсгалын дараа төрсөн лидерүүдийн ихэнхи нь хэлмэгдэн, амиа цаг бусаар алдаж Монголын улс төрийн тавцан эзгүйрсэн, **хоёрдугаарт:** 1940 онд МАХН-ын X их хурал хуралдаж, эндээс Ю.Цэдэнбал, Д.Дамба, Ч.Сүрэнжав, Г.Бумцэнд зэрэг шинэ лидерүүд төрөн гарсан, **гуравдугаарт:** 1940 онд шинэ үндсэн хуулийг баталж уг хуульд иргэдийн шилдэг идэвхтэй хэсэг эвлэлдэн нэгдэх МАХН нь улс нийгмийн бүх байгууллагуудыг удирдан чиглүүлэх гол хүчин гэсэн заалтын дагуу МАХН болон монголын улс төрийн тогтолцоо тодорхой нэг хэв загвартаа орох эхлэл тавигдсан, **дөрөвдүгээрт:** МАХН-ын X их хурлаас хойш дараагийн их хурлууд 4-7 жилийн хугацаанд хуралдаж, нэр томъёоны хувьд 1943 оны 12-р сард МАХН-ын тэргүүлэгч<sup>44</sup> гэсэн албан тушаалыг “Улс төрийн товчоо” (УТТ гэж товчлох), болгож өөрчлөн зохион байгуулагдсан (Болдбаатар. Ж, 1985) зэргийг иш үндэс болгож байгаа юм.

**Хоёрдугаарт:** Улмаар дэлхийн II дайны дараа хуралдсан XI их хурлаас МАХН-ын Намын Төв Хороо, Улс төрийн товчооны гишүүн (УТТ-ны гишүүн гэж товчлох), Улс төрийн товчооны орлогч гишүүн (УТТ-ны орлогч гишүүн гэж товчлох), Ерөнхий нарийн бичгийн дарга (цаашид ЕНБД гэж товчлох), 2-р Нарийн бичгийн дарга (НБД гэж товчлох) гэсэн бүтцэд анх удаа хүмүүс сонгогдсон. Энэ бүтэц нь бага зэргийн зэргийн засварыг эс тооцвол өөрчлөгдөлгүй явсаар 1990 онтой золгож социалист тогтолцоо задарч, УТТ бүрэлдхүүнээрээ огцорч МАХН-ын удирдан чиглүүлэх үүргийг албан ёсоор үгүй болгосноор (МАХН-ын Төв хорооны VIII бүгд хурлын материал, 1990) дуусгавар болжээ. Удалгүй УТТ гэсэн албан тушаалыг 1990 оны 4-р сард МАХН-ын Онц их хурлаар албан ёсоор татан буулгаж МАХН-ын Төв хорооны тэргүүлэгч гишүүн гэж нэрлэжээ.

**Гуравдугаарт:** Үүнд хамгийн чухал албан тушаал нь УТТ-ны гишүүн, орлогч гишүүн, ЕНБД, НБД, Намын хянан шалгах хорооны дарга (цаашид НХШХД гэж товчлох) зэрэг болно. Жич тэмдэглэхэд XV их хурлаас буюу 1966 онд 2-р НБД гэсэн албан тушаалыг байхгүй болгосон байна. 1981 онд хуралдсан XVIII их хурлаар МАХН-ын Төв Хорооны (ТХ гэж товчлох) ЕНБД гэсэн албыг дахин бий болгосон.

## **2. МАХН-ын их хурал ба төвлөн удирдах ёс бэхжсэн нь.**

1940-1990 оны хооронд<sup>45</sup> нийтдээ 10 их хурал (Болдбаатар. Ж, 1985) хуралдсан бөгөөд их хурал хоорондын хугацаа нь 3 жилээс 7 жилийн зайтай

---

<sup>44</sup> 1940 онд сонгогдсон тэргүүлэгчдийг УТТ гишүүн болгон сонгосон учраас бид УТТ гишүүнтэй дүйцүүлэн судалгаандаа хэрэглэсэн болно. (Ч.Тамир)

<sup>45</sup> Судалгааны энэхүү хэсэг нь цаг хугацааны хувьд МАХН-ын X их хурлаас 1990 онд хуралдсан онц их хурлын өмнө МАХН өөрийн удирдан чиглүүлэх үүрэг ролиосоо татгалзсанаар дуусгавар болжээ.

байжээ. Нийтдээ их хурал хоорондын дундаж хугацаа нь 5.5 жилд нэг удаа хуралдаж байжээ.

	МАХН-ын их хурал/ хугацаа	Гишүүдийн тоо	Төлөөлөгчийн тоо	ТХ-ны Ж-Гиш	ТХ-ны Орлогч гиш	Тэр/УТТ орлогч	Хянан шалгах	Төл	Хугацаа
1	1940-3-р сарын 20. X их хурал	13385	634	41	10	8		21.1	6
2	1947-12-2-23. XI их хурал	28000	480	59	11			58.3	7
3	1954-11-19-24. XII их хурал	31741	634	65	25			50	7
4	1958-3-17. XIII их хурал	42896	617	75	47			69.5	4
5	1961-7-3-7. XIV их хурал	43796	688	75	51		ТШБК 15	63.6	3
6	1966-6-1-11. XV их хурал	48570	747	75	51		ТШБК 21	65	5
7	1971-7-11. XVI их хурал	58048	784	83	55		ТШБК 21	74	5
8	1976-6-14-18. XVII их хурал	66900	813	91	61		ТШБК 31	82.2	5
9	1981-5-26-30. XVIII их хурал	76240	824	91	71	8-2	ТШБК 31	92.5	5
10	1986 XIX их хурал	89318	841	85	65			106.2	5
11	1990 оны онц их хурал								4
	<b>Дундаж хугацаа</b>								5.5

1940-1954 он хүртэл буюу Х.Чойбалсан амьд сэрүүн, Ю.Цэдэнбал бүрэн дарангуйллаа тогтоохын төлөө тэмцэж байсан тэр үед их хурлыг дунджаар 6.6 жилд нэг удаа хийж байжээ. Улмаар Х.Чойбалсан нас барсны дараа 1954-1966 он хүртэл намын их хурлыг дунджаар 3.5 жилд хийдэг болж хугацаа нь бараг 2 дахин багассан нь ихээхэн ялгаатай байгааг харуулна. Эл зурвас цаг үед ардчилал соёлж Ю.Цэдэнбалын эсрэг сөрөг хүчин бүрэлдэж эхэлж засгийн эрхийн төлөө ширүүн тэмцэл хийгдсэн цаг хугацаатай давхцаж байна. Улмаар 1966 гэхэд сая Ю.Цэдэнбал сөрөг хүчнийг тас цохин хаяж хэлмэгдүүлэн намын удирдлагыг цэвэрлэж өөрийн талынхнаар дүүргэж ганцаар удирдах ёсыг бүрэн тогтоожээ. Энэ үеэс эхлэн (1966 оноос) их хурлыг 5 жилд нэг удаа хийх болж хэвшсэн бөгөөд энэ тогтсон дэг жаягийг 1990 онд хүрч байж эвджээ.

Улируулан үзэхүл 1921-1934 онд нийтдээ МАХН-ын 9 их хурал (I-IX) хуралдсан бөгөөд хурал хоорондын дундаж хугацаа нь 1.6 жил болж байна. Харин 1940 оноос хойш хуралдсан 10 их хурал (X-XIX) хоорондын дундаж хугацаа нь 5.5 жил болж өмнөхөөсөө 3.6 дахин уртасжээ. Дээрх тоо ба баримтууд нь шууд уялдаатай байна. Таамаглалын дагуу их хурал хуралдах хугацаа ба МАХН-ын дотоод ардчилал хоёр урвуу хамааралтай, их хурал хэдий чинээ богино хугацаанд хуралдана, төдийчинээ дотоод ардчилал сайжирдаг, улмаар удирдлага нь сольж чаддаг байгаа бол эсрэгээр хурал хоорондын хугацаа нь ихсэх тусам ганцаарчлан, төвлөн удирдах дэглэм нь нэг буюу бүлэг хүний дарангуйлах тогтолцоог үүсгэдэг байжээ. Энэ зүй тогтол зөвхөн МАХН-д биш бусад намуудад цаашилбал ТББ-д хамаатай гэж хэлж болох болов уу.

Судалгаанаас харахад МАХН-ын гишүүдийн тоо өсөх тусам их хурлын гишүүдийн төлөөлөх чадвар нь багасч байжээ. 1940 онд хуралдсан Х их хурал төлөөлөгчдийн төлөөлөх чадвар 21.1 байсан бол 1986 онд 106.2 болж яг 5 дахин багассан юм. Үүний дагуу дээрх хугацаанд НТХ-ны гишүүний тоо 41-ээс 85 болж, орлогч гишүүдийн тоо 10-аас 65 болж өсжээ. Ингэж гишүүдийн тоо ихэсч их хурлын төлөөлөгч гишүүдийн тоо өсөх тусам М.Веберийн дэвшүүлсэн “бюрократи ёс” улам бүр бэхжиж байв. Үүний дагуу МАХН-ын бүтэц улам бүр нүсэр болж, шат дамжлага ихсэж, шийдвэр гаргах үйл явц удааширч, төвлөрч эхэлжээ. М.Веберийн эл санаан дээр тулгуурлан Р.Михельс Германы СДН-ын дотоод харилцааг судалж өөрийн олигархын хуулийг томъёолсон байдаг.

### 3. МАХН-ын Улс төрийн товчоо.

Социализмын үеийн монгол нь эрх баригч нэг намтай, тэр нам нь төрийг бүхэлд нь удирддаг байсан учраас хязгааргүй их эрх мэдэлтэй байв. Тэгвэл намын дотоодод жинхэн эрх мэдэл хэний гарт байв? Үүнийг тус намын дүрэм журмын түүхэн хувьслаас нь харьцуулж үзье.

1940 оны 3-р сарын МАХН-ын Х их хурлаар баталсан МАХН-ын дүрмийн 26-р зүйлд “Намын Төв Хороо нь их хурлуудын завсарт намын бүх ажлыг удирдана”, 27-р зүйлд “Намын Төв Хороо нь өөрийн бүгд хурлыг жилд нэгэн удаа хуралдуулна”, 28-р зүйлд “Намын Төв Хороо нь намын бодлогын асуудлуудыг өөрийн бүгд хурлаар хянан хэлэлцэж тогтоох бөгөөд **өдөр тутмын гүйцэтгэх ажлыг эрхлүүлэхийн (тодруулав Ч.Т)** тулд намын бүгд хурал нь **Намын төв хорооны тэргүүлэгчид ба нарийн бичгийн дарга нарыг** тус бүгд хурлаас тогтоосон тоогоор сонгоно”(МАХН-ын программ, дүрэм, 1980) гэж заажээ. Ингэж НТХ нь намын бүх ажлыг удирдана гэж заасан ч бүгд хурлыг жилд нэг удаа хийнэ гэсэн заалтыг оруулсан нь практик дээр хэрэгжих ямар ч боломжгүй байв. Мөн дээр дурдсаны дагуу НТХ бүгд хурлаасаа тэргүүлэгчдийг зөвхөн өдөр тутмын гүйцэтгэх ажлыг эрхлүүлэхийн тулд бүгд хурлаас нарийн бичгийн даргатай хамт сонгодог байжээ. Улмаар намын аппарат нь тэргүүлэгчдээс батлагдсан тусгай дүрмийг удирдлага болгох бөгөөд харин хэлтсийг дүрмэнд нарийвчлан заасан. Үүнээс харахад тэргүүлэгчдийн эрх хэмжээ нь ихээхэн хязгаарлалттай байсан нь харагдаж байна. Тэгвэл нэгэнт сонгогдсон тэргүүлэгчийг огцруулах асуудлыг мөн дүрмэнд оруулсан. Дүрэмд 25-р зүйлд “Намын Төв Хороо ...нь их хурлаас тогтоогдсон гишүүдээс сонгогдоно. Хэрэв Намын Төв Хорооны гишүүдээс орон гарвал их хурлуудаас сонгогдсон орлогчдоос нөхөн оруулна (МАХН-ын программ, дүрэм, 1980) гэж заажээ. Тиймээс хэрвээ “НТХ-ноос хүн хасагдах юм бол их хурлуудаас сонгогдсон орлогчдоос нөхөн оруулна” гэж заасан. Ийм дүрмээр 1940-1947 он хүртэл ажилласан. Улмаар XI их хурлаас дээрх дүрмийг бараг хэвээр нь баталсан боловч өмнө өөрчлөөд байсан ганц заалтыг оруулсан. Тэргүүлэгчид гэдгийг УТТ гэж өөрчилжээ. Үүнд 35-р зүйлд “НТХ-нь улс төрийн ажлуудыг **эрхлэх** улс төрийн товчоо ...байгуулна” (МАХН-ын программ, дүрэм, 1980) гэжээ. Энэ хэсэгт улс төрийн ажил эрхлэнэ гэсэн ерөнхий үгээр халхавч хийн



УТТ-ны эрх мэдлийг өргөтгөж эхэлснийг ажиглаж болно. Улмаар 1954 онд хуралдсан XII их хурлаас дүрмийн 37-р зүйлд “МАХН-ын ТХ нь бүгд хурлын завсарт Төв Хорооны ажлыг **удирдуулахын** тул Улс төрийн Товчоог ...байгуулна” (МАХН-ын программ, дүрэм, 1980) хэмээн өөрчлөлт оруулсан нь УТТ анх удаа бүх эрх мэдлийг дүрмээр баталгаажуулсан хэрэг байв. Үүнд Улс төрийн товчоог томоор бичдэг болсноос гадна ТХ-г удирдуулах үүргийг УТТ дүрмийн дагуу албан ёсоор оруулсан байна. Ингэж ганцхан үг өөрчилснөөр УТТ хэмжээ хязгааргүй эрх хэмжээтэй тийм байгууллага болон хувирсан юм. Ийм шийдвэрийг албан ёсоор 1954 оноос эхлэн хууль ёсны шинжтэй болгож улмаар 1990 он хүртэл үргэлжилжээ. Үүнийг албан ёсоор МАХН-ын түүхийн номонд “МАХН-ын Төв хорооны үүрэг, байр суурь суларч түүнийг үнэн хэрэгтээ Улс төрийн товчоо төлөөлөх болжээ”. (Монгол ардын хувьсгалт намын түүхэн замнал, 1995) хэмээн дүгнэжээ.

Тиймээс цаашид монголын тоталитар дэглэмийг 1940-1954 он хүртэл, 1954-1990 он гэж хоёр хуваан өөр хооронд нь ялгаатай нарийвчлан судлах шаардлагатай гэдэг нь харагдаж байна.

(Үргэлжлэл бий)

#### Ном зохиол

1. Ю.Атар. (1997). Монгол оронд тогтсон улс төрийн авторитари дэглэм түүний үр дагавар. . In
2. Б.Батчулуун. (2003). Пост коммунист нийгэм дэх төр иргэний харилцаа. УБ
3. Ж.Болдбаатар. (2004). Түүх зулсан он жилүүдийн ойллого. УБ
4. Ж.Болдбаатар, Ч.Дашдаваа. (2005). Шинэчлэлийн төлөө хөдөлгөөн, түүний хувь заяа. УБ: Соёмбо .
5. Ж.Болдбаатар. М. Д. (1985). МАХН-ын үйл ажиллагаанд намын их хурал, Төв хорооны бүгд хурлуудын роль. УБ: Улсын хэвлэлийн газар
6. Ж.Болдбаатар., Ч.Дашдаваа . (2005). Шинэчлэлийн төлөө хөдөлгөөн, түүний хувь заяа. УБ
7. Ч.Болдбаатар. (2004). ХХ зууны Монголын улс төрийн зүтгэлтнүүд. УБ: Адмон
8. Б.Болд-Эрдэнэ. (2000). Монголын улс төрийн нам, намын систем. УБ.
9. Д.Ганбат. (2007). ХХ зууны ардчиллын хөгжил ба Монгол улс. Шинэ толь , 5-17
10. Ц.Ганболд. (1997). Монгол дахь улс төрийн модернизацийн зарим онцлог. Эрдэм шинжилгээний бичиг , 44-48
11. А.Гидденс. (2006). Социологи. УБ: Адмон
12. Х.Гүндсамбуу. (2002). ХХ зуун Монголын нийгмийн давхраажил хөгжил хандлага . УБ
13. Ё.Довчин. (2000). Степная политическая культура. Санкт-Петербург.
14. О.Крыштановская. (2004). Анатомия Российской Элиты. Москва
15. МАХН-ын программ, дүрэм (pp. 176-177). УБ: Улсын хэвлэлийн газар (1980).
16. МАХН-ын Онц их хурлын материал . (1992). УБ: Улсын хэвлэлийн газар

17. МАХН-ын Төв хорооны VIII бүгд хурлын материал. (1990 ). УБ: Улсын хэвлэлийн газар
18. Монгол ардын хувьсгалт намын түүхэн замнал. (1995). УБ
19. Монголын нийгмийн хувь заяаны тулгамдсан асуудлууд (pp. 97-119). УБ.
20. Ч.Өлзийсайхан. (2003). Монгол дахь улс төрийн элитийн хэв маягийн өөрчлөлт, төлөвшилтийн зарим асуудал. Социологи , 69-72
21. Улс төр судлал. (2002). УБ.
22. УТБА-ийн лекцийн эмхэтгэл. (2001). УБ.
23. Б.Ралгаа. (1998). Улс төрийн авторитари дэглэмээс сэхээтнүүдийг хэлмэгдүүлсэн түүний хор уршиг. МУИС-ийн ЭШБ , 41.
24. Б.Чимид. (1995). Монгол улсын үндсэн хуулийн үзэл баримтлал. Шинэ толь .Г.Алмонд нар. (2000). Харьцуулсан улс төр. УБ: МУИС-ийн хэвлэх үйлдвэр.
25. Г.Чулуунбаатар. (1994). Шилжилтийн үеийн ардчилал, улс төрийн тогтолцооны монгол хувилбарын тухайд. Шинэ толь , 54.
26. Д.Чулуунжав. (1998). Монголын төрийн тогтоцоо, түүний хууль эрхийн үндсүүд дэх дутагдал, согог, асуудлууд. УБ: Эрдэм.
27. С.Чулуунбаатар. (1995). 1990 оны үндэсний ардчилсан хувьсгал. In М.Санждорж, ХХ зууны монгол (pp. 102-108). Эрдэм .
28. Ц.Элбэгдорж. (1995). Ардчилсан хувьсгалын үйл явц, өнөөгийн байдал. Шинэ толь .
29. А.Цанжид. (1999). Монгол улсын үндсэн хуулийн үзэл баримтлалын асуудал. УТБА-ийн лекцийн эмхэтгэл , 25.

### **Гадаад хэл дээр**

1. Linz J. J. (2000). Totalitarian and Authoritarian regimes
2. А. Юндэндорж. (2000). Особенности политической системы Монголии в условиях перехода к конституционализму. УБ

### **Abstract**

The purpose of this research paper is to define the role of institutions and rules in the two different models of totalitarian regimes. Main hypothesis role of institution in totalitarian regime had increased after Stalin's death. The author used institutional approach to this historical study.

This research can prove that Politburo changed one article of the Party rule. As a result of this change Politburo received power from Central Committee of Party illegally. Since that time this change had been kept until the socialist system collapsed in 1990.

MPRP's Politburo had taken all power without any control from Central Committee and Assembly of the Party after making this revision. Therefore, I would conclude that Mongolian totalitarian system had changed from classic totalitarianism to collective totalitarianism. This change occurred in 1954.